

# Баялгийн засаглалын индекс 2021

## Монгол Улс




Уул уурхай

Монгол Улсын уул уурхайн салбар нь 2021 оны Баялгийн засаглалын индекс (БЗИ)-г авч болох 100 онооноос 70 оноо авсан нь 2017 оны индексийн үнэлгээнээс 6 оноогоор өссөн үзүүлэлт юм. “Үнэ цэнэ хүртэх байдал” болон “Орлогын менежмент”-ийн үнэлгээ “хангалттай” ангилалд эргэлзээгүй багтсан бол “Дэмжигч орчин”-ы хувьд ахиц дэвшил гаргасан байдал нь энэ хэсэгт “сайн” гэсэн үнэлгээ авахад нөлөөлжээ. Гэхдээ голлох зарим асуудлыг тусгайлан анхаарах замаар Монгол Улс баялгийн засаглалаа улам сайжруулах боломж байна.

- Эрх зүйн орчин болон холбогдох мэдээллийг ил тайлагнах байдалд ухралт гарсны улмаас “Орон нутгийн үр нөлөө”-тэй холбоотой засаглалын үнэлгээ 2017 оны БЗИ-ээс 14 оноогоор буурсан байна.
- Монгол Улс 2017 оноос хойш харьцангуй цөөн тооны хайгуулын лиценз шинээр олгосон боловч лиценз олгосны дараах үеийн харилцааг зохицуулсан эрх зүйн болон ил тод байдлын шийдэгдээгүй асуудлууд тулгамдсан хэвээр байна. Олборлох салбарын компаниудын ашиг хүртэгч эздийн талаарх мэдээлэл болон гэрээ хэлэлцээрийг нийтлэхийг шаардсан хууль тогтоомж дутагдалтай байна.
- Монгол Улсын Засгийн газрын цахим шилжилт хийх чиглэлд гаргаж буй ахиц дэвшлээс үүдэн “Нээлттэй өгөгдөл”-ийн дэд хэсэгт өндөр үнэлгээ авсан нь уул уурхайн салбарын голлох өгөгдөл, мэдээллийг авах боломжгүй байсаар байгааг далдалж байна.
- Монгол Улсын уул уурхайн салбарт, ялангуяа орон нутгийн үр нөлөө, орон нутагт баялгийн орлогыг хуваарилах талаар батлагдсан хууль тогтоомж болон тэдгээрийн хэрэгжилтийн хооронд зөрүүтэй байдал оршин байна.
- Монгол Улсын Засгийн газар нь олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн төрийн өмчит компани (ТӨК)-аас санхүүгийн хувьд хэт хамааралтай байгаа энэ үед “ТӨК-ийн засаглал”-ын хувьд “хангалтгүй” үнэлгээтэй хэвээр байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

### Монгол Улсын уул уурхайн салбар: 2021 оны Баялгийн засаглалын индекс ба бүрэлдэхүүн хэсгийн оноо



# Баялгийн засаглалын индекс 2021

## БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКСИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Монгол Улсын баялгийн засаглалд ахиц дэвшил ажиглагдаж байгаа боловч анхаарах шаардлагатай зарим асуудал тулгамдсан хэвээр байна.

Монгол Улсын эдийн засаг уул уурхай, эрдэс бүтээгдэхүүний салбараас ихээхэн хамааралтай бөгөөд бараа бүтээгдэхүүний экспортын 85 гаруй хувийг металл болон хүдрийн бүтээгдэхүүн эзэлж байна. 2021 оны БЗИ нь 2019 онд бараа бүтээгдэхүүний экспортын 22 хувийг бүрдүүлсэн, нүүрсний салбарын хамт Монгол Улсын уул уурхайн хамгийн чухал салбар хэвээр байгаа зэс үйлдвэрлэлийн салбарыг үнэлсэн болно.

“Орлогын менежмент” болон “Дэмжигч орчин”-ы хувьд ахиц гарснаар Монгол Улсын 2021 оны БЗИ нь нийт 100 онооноос 70 оноо болж, үнэлгээ нь 6 оноогоор өссөн бол “Орон нутгийн үр нөлөө” хэсэгт анхаарал татсан асуудлууд нэмэгдсэний улмаас “Үнэ цэнэ хүртэх байдал” үзүүлэлт 2 оноогоор буурчээ.

### МОНГОЛ УЛСЫН 2017 БОЛОН 2021 ОНЫ БЗИ-ИЙН ОНОО

	2017 БЗИ	2021 БЗИ	Өөрчлөлт
<b>БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС</b>	64	70	6
<b>ҮНЭ ЦЭНЭ ХҮРТЭХ БАЙДАЛ</b>	63	61	-2
Тусгай зөвшөөрөл	61	61	0
Татвар	85	85	0
Орон нутгийн үр нөлөө	67	53	-14
Төрийн өмчит компани	40	44	4
<b>ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ</b>	54	71	17
Улсын төсвийн төлөвлөлт	48	75	27
Орон нутагт баялгийн орлого хуваарилах	74	53	-21
Үндэсний баялгийн сан	42	86	44
<b>ДЭМЖИГЧ ОРЧИН</b>	73	78	5
Дуу хоолой ба эгэх хариуцлага	83	86	3
Төр засгийн үр дүнтэй ажиллагаа	57	61	4
Зохицуулалтын чанар	63	77	14
Хууль дээдлэх байдал	65	73	8
Авлигын хяналт	62	60	-2
Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийллээс ангид байдал	89	93	4
Нээлттэй өгөгдөл	92	99	7
<b>ХУУЛЬ</b>	73	75	2
<b>ХЭРЭГЖИЛТ</b>	53	59	6
<b>ХУУЛЬ ДҮРЭМ БОЛОН БОДИТ ХЭРЭГЖИЛТИЙН ЗӨРҮҮ</b>	-20	-16	4

# Баялгийн засаглалын индекс 2021

## ҮНЭ ЦЭНЭ ХҮРТЭХ БАЙДАЛ

**Лиценз олголтын хувьд үнэлгээ өөрчлөгдөөгүй боловч байгаль орчны хууль тогтоомж, ил тайлагналд ухралт гарсан нь "Орон нутгийн үр нөлөө"-ний үнэлгээ буурахад хүргэсэн**

“Лиценз олголт”-оор Монгол Улсын үнэлгээ 2017 оны БЗИ-ээс хойш өөрчлөгдөөгүй боловч тэр үеэс хойш холбогдох төрийн байгууллага нь харьцангуй цөөн лиценз шинээр олгосон болно.

Монгол Улсад олборлох салбарын компаниудтай байгуулсан гэрээг нийтлэх, мөн олборлох салбарын компаниудын ашиг хүртэгч эздийн талаарх мэдээллийг ил болгохыг шаардсан хууль тогтоомж дутагдалтай байгаа нь анхаарал татаж байна. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2018 оны тайланд ашиг хүртэгч эздийн талаарх мэдээллийг хязгаарлагдмал хэмжээнд тайлагнасан боловч энэ нь бүх аж ахуйн нэгжийг хамарсан, түгээмэл шинжтэй биш байна. Түүнчлэн Авлигатай тэмцэх тухай хуулиар төрийн өндөр албан тушаалтнууд нь олборлох салбарын компаниудад эзэмшиж буй хөрөнгөө ил болгож, түүнийг нь Авлигатай тэмцэх газар олон нийтэд мэдээлэхийг шаарддаг боловч хэрэгжилт нь бүрэн бус байна. Ашиг хүртэгч эздийн мэдээлэл, төрийн албан тушаалтнуудын эзэмшиж буй хөрөнгийн мэдээллийг ил тайлагнах нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд нэн чухал нөлөөтэй. Монгол Улсын хууль тогтоох байгууллага энэ чиглэлд илүү чанга хууль тогтоомж батлах шаардлагатай.

Мөн орон нутгийн үр нөлөөг зохицуулахад анхаарал хандуулах шаардлагатай. Хуульд зааснаар компаниуд ашиглалтын лиценз авах өргөдөл гаргахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх, Байгаль орчны тухай хуульд нийцүүлэн тэрхүү үнэлгээг олон нийтэд мэдээлэх ёстой боловч хүлээн авсан бүх үнэлгээг төрийн цахим талбаруудад нэг бүрчлэн мэдээлэхгүй байна. Үүний нэгэн адилаар нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг олон нийтэд төдийлөн мэдээлэхгүй байна. Нөхөн сэргээлт хийх, олборлолтын төслүүдийг хаахтай холбоотой үйл ажиллагааны талаар олон нийтэд хангалтгүй мэдээлэл хүргэж байна.

## ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ

**Орлогын менежментэд ахиц дэвшил гарсан нь Монгол Улсын үндэсний баялгийн сантай холбоотой сул талуудыг далдалж байна**

Үндэсний баялгийн сангийн засаглалд ахиц дэвшил гарснаар “Орлогын менежмент”-ийн хувьд Монгол Улс 100-аас 71 оноо авсан нь өмнөх индексээс 17 оноогоор ахисан үзүүлэлт юм. Гэхдээ үнэлгээ ингэж ахисан нь зарим талаараа төөрөгдөл үүсгэхээр байна. Эрдэс баялгийн орлогыг ирээдүй хойч үеийнхэнд хуваарилах зорилгоор 2016 онд шинээр батлагдсан хууль хэрэгжиж эхэлснээс хойш уул уурхайн салбараас олох орлогоос “Ирээдүйн өв сан” (ИӨС)-д хуримтлуулахад зарим нэг ахиц дэвшил гараад байгаа боловч төрийн зүгээс уг сангийн хөрөнгийг удирдах корпорацыг хараахан байгуулаагүй байна. Мөн ИӨС-д хуримтлагдсан хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийгдээгүй байна. Засгийн газраас ИӨС-ийн тухай хуулийн хэрэгжилтийг зохих ёсоор хангаж, хөрөнгө оруулалтыг эрхлэх байгууллагыг ажиллаж эхлэхээс өмнө илүү чанд дүрэм, журмыг батлах чиглэлд анхаарах хэрэгтэй.

Төсвийн тусгай шаардлага буюу дүрмийг мөрддөг боловч жил бүр дүрэмд өөрчлөлт оруулж байгаа нь тэдгээрийн үр нөлөөг бууруулж байна. Улмаар Монгол Улсын Засгийн газар төсвийн дүрмийн тухайд хатуу сахилга батыг нэн даруй хэрэгжүүлж, дараагийн төсвийн жилд дагаж мөрдүүлэх шаардлагатай.

# Баялгийн засаглалын индекс 2021

## НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

**Монгол Улсын нээлттэй өгөгдлийн ерөнхий менежменттэй холбоотой давуу талууд нь уул уурхайн салбарын голлох чиглэлийн мэдээллийн цахим хүртээмж дутагдалтай байгааг далдалж байна**

Засгийн газраас цахим шилжилт хийх, цахим засаглалын дэд бүтцийг бий болгох чиглэлд идэвхтэй ажиллаж байгаа тул нээлттэй өгөгдлийн засаглалын хувьд Монгол Улс 100-аас 99 оноо авчээ. Гэвч нээлттэй өгөгдлийн зарчмыг мөрдөж байгаа нь уул уурхайн салбарт тэр бүр тусгалаа олохгүй байна. Монгол Улсын Засгийн газар нь ашигт малтмалын нөөц, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорттой холбоотой цахим өгөгдлийн төвлөрсөн портал үүсгээгүй бөгөөд ил болгож буй мэдээлэл нь гол төлөв зөвхөн текст хэлбэртэй байна. Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар экспортын болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийг лицензгүйгээр ашиглах ба компьютерт уншуулж болох хэлбэрээр нийтэлдэг боловч холбогдох бусад байгууллагууд ийм хэлбэрээр нийтлэхгүй байна. Улсын уул уурхайн кадастрын мэдээллийг цахимаар үзэх боломжтой боловч татаж авах боломж нь хязгаарлагдмал, хэрэглэгчид газар зүйн орон зайн өгөгдлийг татаж авах боломжгүй байна.

Иймд Монгол Улсын Засгийн газар програмчлалын аргаар холбогдох (API) хэлбэрээр өгөгдөлд хандах боломжтой цахим талбаруудыг бий болгох, мөн өгөгдлийг лицензгүйгээр ашиглах ба компьютерт уншуулж болох хэлбэрээр авах боломжийг хангах замаар цахим тайлагналыг сайжруулах чиглэлд ажиллах ёстой. Засгийн газар нь голлох яам, оролцогч талуудын хамтаар Монгол Улсын уул уурхайн салбарын төлөв байдлыг иж бүрэн тоймлох боломжийг олгохуйц, баялгийн нөөц, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортын хамгийн шуурхай статистик мэдээллийг агуулсан нэгдсэн порталыг бий болгох шаардлагатай.


## ХУУЛЬ ДҮРЭМ БОЛОН БОДИТ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

**2017 оны БЗИ-ээс хойш “хэрэгжилтийн зөрүү” багасаж байгаа боловч “Орон нутгийн үр нөлөө”, “Орон нутагт баялгийн орлогыг хуваарилах”-тай холбоотой хуулийн хэрэгжилт доройтсон байна**

Монгол Улсад батлагдсан хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийн хооронд зөрүү байсаар байна. 2017 болон 2021 оны индексийн хооронд хэрэгжилтийн зөрүүний үнэлгээ 20-оос 16 оноо болон буурсан боловч орон нутгийн үр нөлөө, орон нутагт баялгийн орлогыг хуваарилахтай холбоотой ил тайлагнал, хууль хэрэгжилт хангалтгүй байна. Хуулиар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хүлээн авч, олон нийтэд мэдээлэх ёстой боловч үнэлгээг бүрэн нийтлэхгүй байна. Түүнчлэн Төрийн аудитын тухай хуульд зааснаар Монгол Улсын Үндэсний аудитын газар нь баялгийн орлогын шилжүүлгүүдэд аудит хийх үүрэгтэй боловч энэ үүргээ хэрэгжүүлээгүй буюу сүүлд гаргасан аудитын тайландаа тусгаж нийтлээгүй байна.

Ил болгоогүй тайлан, хийгдээгүй аудит нь уул уурхайгаас байгальд орчинд үзүүлэх нөлөөлөл, баялгийн орлогын урсгал, хэмжээ, хуваарилалтын талаарх олон нийтийн ойлголт төлөвшихөд саад учруулж байгаа тул хууль дүрэм ба бодит практикийн зөрүү нь анхаарвал зохих асуудал юм. Уул уурхайн салбарын менежментийн талаар магадлах боломжийг иргэний нийгмийн байгууллагууд, иргэдэд олгохын тулд Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, аудитын гол байгууллагууд эдгээр мэдээллийг ил тод мэдээлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ БОЛОН БОДИТ ХЭРЭГЖИЛТИЙН ЗӨРҮҮ



# Баялгийн засаглалын индекс 2021

## ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ТӨК-ийн засаглал “хангалтгүй” үнэлгээтэй хэвээр байгаа нь Монгол Улсын 2021 оны БЗИ-т хамгийн муу үнэлгээ авсан үзүүлэлт болжээ

2021 оны БЗИ нь “Эрдэнэс Монгол”-ыг тусгайлан үнэлсэн хэдий ч Засгийн газар нь Монгол Улсын уул уурхайн салбарт ажиллаж буй хэд хэдэн ТӨК-аас ихээхэн хамааралтай байна.

2017 оны БЗИ нийтлэгдсэнээс хойш 5 сая төгрөгөөс дээш санхүүгийн бүх гүйлгээ, түүний дотор орлогоо ил тайлагнахыг үүрэг болгосон Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлснээр ТӨК-ийн санхүүгийн тайлагналд тодорхой ахиц гарсан. Баялгийн орлогыг ТӨК ил тод, хариуцлагатай удирдах явдлыг баталгаажуулахын тулд компаниуд ил тод байдлыг хангах хууль тогтоомжийг мөрдөх, тайлагнах, ил тод мэдээлэх нөхцөлийг Засгийн газрын зүгээс үргэлжлүүлэн хангах шаардлагатай.

2021 оны индексийн зарим үзүүлэлтийн хувьд “Эрдэнэс Монгол” нь “муу” үнэлгээ авсан байна. Тус ТӨК нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээлэл, эрдэс бүтээгдэхүүний борлуулалтын орлого, бүтээгдэхүүний зах зээлийн талаарх ач холбогдол бүхий мэдээллийг ил нийтэлдэггүй. Мөн тус ТӨК нь 2018 оноос хойш санхүүгийн тайлангаа олон нийтэд мэдээлээгүй бөгөөд хамгийн сүүлийн жилийн тайлан нь 2017 онд нийтлэгдсэн. Түүнчлэн компанийн засаглалтай холбоотой асуудлууд байгаа төдийгүй “Эрдэнэс Монгол”-ын ёс зүйн дүрэм, ТУЗ-ийн бүрэлдэхүүний талаарх шинэчлэгдсэн мэдээлэл олон нийтэд нээлттэй бус байгаа тул иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус компанийн үйл ажиллагаа, стратегийн чиглэлд хангалттай хяналт тавьж чадахгүйд хүргэж байна.

Цаашилбал Засгийн газар “Эрдэнэс Монгол”-ыг төсвийн шинжтэй үйл ажиллагаанд татан оролцуулж ирсэн. Тухайлбал, дэд бүтэц барих ажилд оролцож ирсэн төдийгүй “Эрдэнэс Монгол”-ын нэг охин компани 2020 онд тэтгэврээр барьцаалсан зээлийн төлбөрөөс иргэдийг чөлөөлөх ажлыг санхүүжүүлсэн. Эдгээр бизнесийн үндсэн бус үйл ажиллагаанд ТӨК-ийг ашиглах нь Засгийн газрын санхүүгийн талаар бүрэн бус ойлголт авах, үнэн хэрэгтээ төсвийн гэж үзэж болох зарцуулалтад олон нийтийн тавих хяналтыг сулруулах талтай.

ТӨК-уудаас ихээхэн хамааралтай орны хувьд Монгол Улсын Засгийн газар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрдэс бүтээгдэхүүний борлуулалтын статистик мэдээллийг ил тод мэдээлж байх шаардлагатай бөгөөд ингэснээр иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус салбарын орлогын урсгал, менежментийн талаар мэдээлэл авах боломжтой болох юм. ТӨК-ийн стратегийн чиглэлийг хэн тодорхойлж байгааг, мөн удирдлага нь улс төрийн нөлөөллөөс ангид эсэхийг олон нийт ойлгох боломжийг бүрдүүлэхэд компанийн засаглалыг нь шинэчлэх шаардлагатай юм.



Баялгийн засаглалын хүрээнд ахиц дэвшлээ үргэлжлүүлэн нэмэгдүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн зүгээс зөвлөж байна. Үүнд:

- 1. Монгол Улсын Их хурал, Засгийн газар:** Хууль тогтоогчид ашиг хүртэгч эзэд болон гэрээг ил тод болгох асуудлыг зохицуулах хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх чиглэлд шаардлагатай хууль тогтоомжийг батлах хэрэгтэй. Хууль тогтоогчид хөрөнгийн удирдлагын корпорацыг байгуулах болон санхүүгийн хөрөнгө оруулалт хийх явдлыг хангуулах замаар Ирээдүйн өв сан болон Төсвийн тогтворжуулалтын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг баталгаажуулах шаардлагатай. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн Засгийн газар уг санг шинэ баялгийн сангийн хэлбэрт оруулах тохиолдолд хууль эрх зүйн зохих орчныг бүрдүүлж, ил тод, эгэх хариуцлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар баялгийн орлогыг зүй бусаар зарцуулах, санхүүгийн буруу менежмент явагдахаас сэргийлэх нь зүйтэй. Уул уурхайн салбарын орлогын зохистой менежментийг бий болгохын тулд төсвийн ердийн журамд цаг алдалгүй эргэн орох, төсвийн дүрмүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.
- 2. Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар:** Эдгээр байгууллагууд нээлттэй өгөгдлийн зарчмуудыг баримталж, цахим өгөгдөл ашиглах боломжийг сайжруулах шаардлагатай. Лиценз, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын талаарх мэдээллийг илүү нарийвчлалтай, компьютерт уншуулах боломжтой байдлаар цахим хэлбэрээр нийтлэх нь чухал байна. Өгөгдлийг аль болох уул уурхайн төслийн түвшний нарийвчлалтай нийтэлж, тогтмол шинэчилж байх шаардлагатай.
- 3. Эрдэнэс Монгол:** Удирдах ажилтнууд нь ил тод байдал, тайлагналыг сайжруулах шаардлагатай. Тус компани вэбсайтаа шинэчилж, шилдэг туршлагуудыг хэрэгжүүлэх замаар жилийн болон санхүүгийн тайлангаа бэлдэж, ил тод мэдээлэх ёстой. Мөн тус компани бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээлэл, компаниас охин компаниудтайгаа харилцах харилцаа, олсон орлогыг төсвийн шинжтэй зарцуулалтад зориулсан талаар олон нийтэд мэдээлэх нь чухал.
- 4. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын газар, орон нутгийн засаг захиргаа:** Байгаль орчны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй хяналтын гол байгууллагууд болох эдгээр оролцогч талууд нь компаниудын хамт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийтэд иж бүрнээр нь мэдээлэх шаардлагатай юм.

## Баялгийн засаглалын индекс гэж юу вэ?

2021 оны БЗИ нь баялаг ихтэй 18 улс орон газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөц баялгаа хэрхэн удирдаж байгааг үнэлсэн болно. Индексийн ерөнхий үнэлгээ нь гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнээс хоёр нь олборлох салбарын салшгүй онцлог болох “Үнэ цэнэ хүртэх байдал” болон “Орлогын менежмент”-ийг хэмжиж байгаа бол гуравдахь нь засаглалын ерөнхий нөхцөл байдлыг буюу үйл ажиллагааг “Дэмжигч орчин”-г үнэлж байгаа. Засаглалын энэхүү гурван ерөнхий хэмжүүр нь 14 дэд хэсэг буюу 51 үзүүлэлтээс бүрдэх бөгөөд тэдгээрийг нийт 136 асуулыг нэгтгэх замаар үнэлсэн болно.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн хяналтад ажилласан хараат бус судлаачид 18 улсын хувьд үнэ цэнэ хүртэх байдал болон орлогын менежментийн талаар асуулгад хариулж анхдагч өгөгдөл, мэдээллийг цуглуулсан. Гуравдахь бүрдэл хэсгийн хувьд БЗИ нь хөндлөнгийн буюу 20 гаруй олон улсын байгууллагын өгөгдөл, мэдээллийг ашигласан. Энэхүү үнэлгээ нь 2019-2020 оныг хамарна. Индекс болон түүнийг хэрхэн тооцсон талаарх нэмэлт мэдээллийг БЗИ-ийн Аргачлалын баримт-аас авна уу.

